



**“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК**

Тендершалгаруулалтгэр  
ээнийнэр:

**ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХ ХАРЬЦУУЛАЛТЫН ТЕНДЕР**

Тендершалгаруулалтгэ  
рээнийдугаар:

**ЭТТ/201901300**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019 оны 06 дугаар сарын 20-ны өдөр

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **цэвэрлэгээний материал**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 14 цаг 00 минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 14 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендертэй холбоотой мэдээллийг доорхи хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8,  
Финанс төв, 5 давхар 503 тоот  
Утас: +976-7505-5555-504

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**








6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.







7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.








Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт  |
|-------------------------|---|
| ТӨӨЗ 1.1                | <ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 1 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан.</li> <li>2. 2017, 2018 оны аль нэг жилд ижил төстэй бараа гүйцэтгэж байсан туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн 1-ээс доошгүй ажлын гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт</li> <li>3. Компанийн танилцуулга.</li> <li>4. Компанийн гэрчилгээний хуулбар.</li> <li>5. Татварын тодорхойлолт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-д тендер нээх өдрийн байдлаар өргүй байх.</li> <li>6. Шүүхийн төрөлжсөн архивын газраас хариуцагчаар оролцож байгаагүй тухай тодорхойлолт ирүүлэх. /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/</li> <li>7. ШШГЕГ-ын тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/</li> <li>8. Тендерт шалгарсан тохиолдолд техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй бараа нийлүүлвэл захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан бичиг ирүүлэх</li> <li>9. Тендерт шалгарсан тохиолдолд тендерт санал болгосон хугацаандаа нийлүүлээгүй бол захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан бичиг ирүүлэх</li> <li>10. Мэргэжлийн хяналтын лабораторын дүгнэлт</li> </ol> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай эсэх: <b>Үгүй</b></p> |
| ТӨӨЗ 2.1                | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Хаяг: <b>Цахим худалдан авах ажиллагааны систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр /pdf/-ээр илгээнэ.</b></p> <p>Огноо: 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдөр</p> <p>Цаг: 14 цаг 00 минут</p>   |
| ТӨӨЗ 2.1                | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв, Утас: +976-7505-5555-504</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 5 давхар 503 тоот</p> <p>Огноо: 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдөр</p> <p>Цаг: 14 цаг 30 минутад нээнэ.</p>  |
| ТӨӨЗ 6.2                | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй</b></p>  |

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

| № | Барааны нэр                                    | Үзүүлэлт  | Тоо, ширхэг | Дүйцэхүйц барааны зураг   |
|---|--|---|-------------|---|
| 1 | Комет эсвэл түүнтэй дүйцэх                     | 450 грамм   | 396 ш       |    |
| 2 | Нойлын ус өнгө оруулагч                        | Bref эсвэл түүнтэй дүйцэхүйц<br>Боодолдоо 2 ш-тэй | 600 боодол  |    |
| 3 | Эдийн саван                                    | Popular-тэй дүйцэхүйц                             | 360 ш       |   |
| 4 | Порлон аяга угаагч болон түүнтэй дүйцэх        | 11смX7, смX4 см                                   | 132 ш       |  |
| 5 | Резинин нимгэн бээлий                          | Чанартай, размер M,L                              | 180 ш       |  |
| 6 | Аяга таваг угаагч шингэн бодис                 | TRIO-тэй дүйцэхүйц 500 гр                         | 240 ш       |  |
| 7 | Элгэн алчуур /гайхмаараа эсвэл түүнтэй дүйцэх/ | 50см x50см  | 240 ш       |  |

|    |                           |  |       |   |
|----|---------------------------|--|-------|---|
| 8  | Цайруулах, ариутгах бодис | КАО BLEACH<br>эсвэл<br>түүнтэй<br>дүйцэхүйц<br>1.5 л       | 120 ш |    |
| 9  | Угаалгын шингэн бодис     | Капля,<br>Ваниш эсвэл<br>түүнтэй<br>дүйцэхүйц<br>500 грамм | 840 ш |    |
| 10 | 00-и ариутгагч бодис      | Jonhson,<br>Утёнок эсвэл<br>түүнтэй<br>дүйцэхүйц           | 480 ш |    |
| 11 | Агааржуулагч              | Glade эсвэл<br>түүнтэй<br>дүйцэхүйц<br>300 мл              | 360 ш |   |
| 12 | Угаалгын нунтаг           | Tide эсвэл<br>түүнтэй<br>дүйцэхүйц<br>3кг-аас<br>багагүй   | 120 ш |  |
| 13 | Пракет шал угаагч         | Пронто эсвэл<br>түүнтэй<br>дүйцэхүйц<br>750 грамм          | 480 ш |  |
| 14 | Шалны алчуур              | Чанартай,<br>эдэлгээ<br>сайтай, ус<br>сайн авдаг<br>алчуур | 240 ш |   |

|    |   |   |       |   |
|----|---|---|-------|---|
| 15 | Угаалгын бээлийн дотор өмсдөг нимгэн даавуун бээлий | Даавуу материалтай                              | 240 ш |    |
| 16 | Шил арчигч шингэн                                   | Allone эсвэл түүнтэй дүйцэхүйц 500 мл           | 240 ш |    |
| 17 | Автомат шал угаагчийн алчуур                        | Чанартай, дугуй хэлбэртэй                       | 120 ш |    |
| 18 | Гарын шингэн саван                                  | MILANA Алоэ вера эсвэл түүнтэй дүйцэхүйц 4 литр | 120 ш |   |
| 19 | Гарын шингэн саван                                  | MILANA Алоэ вера эсвэл түүнтэй дүйцэхүйц 300 мл | 240 ш |  |
| 20 | Мебель өнгөлөгч                                     | Пронто эсвэл түүнтэй дүйцэхүйц                  | 240 ш |  |
| 21 | Хлормин   | Хайрцгандаа 90-ээс доошгүй ширхэгтэй байх       | 120 ш |  |



1. **Стандарт:** Олон улсын стандартын шаардлагыг хангасан байх ба тухайн ариун цэвэр, цэвэрлэгээний бараа, материалын гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.
2. **Баглаа, боодол:** Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг бүрэн хангасан, мөн Монгол улсын /MNS/ стандартыг хангасан байх. Баглаа боодол нь цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тээвэрлэх шаардлагыг хангасан байна. Баглаа боодол тус бүр дээр тухайн барааны нэр, тоо ширхэг зэргийг бичиж тэмдэглэсэн байна.
3. **Бараа хүргэх газар:** [Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв, Утас: +976-7505-5555-504]
4. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

#### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

| Нэр                                     | Тодорхойлолт                           | Тоо ширхэг                     | Хэмжих нэгж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг               | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа   |   |                                      |
|---|--|--------------------------------|-------------|--|---|---|--------------------------------------|
|   |  |                                |             |  | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа   | Нийлүүлэх эцсийн хугацаа  | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| 1                                       | 2                                      | 3                              | 4           | 5  | 6   | 7   | 8                                    |
| Техникийн тодорхойлолтод заасан нэршлэр | Техникийн тодорхойлолт од заасны дагуу | Техникийн тодорхойлолтын дагуу |             | Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв | <i>Гэрээ 1 жилийн хугацаатай байх ба захиалсан тоо хэмжээг захиалга өгснөөс хойш 1 хоногийн дотор</i> | <i>Гэрээ 1 жилийн хугацаатай байх ба захиалсан тоо хэмжээг захиалга өгснөөс хойш 3 хоногийн дотор</i> |                                      |
|   |  |                                |             |  |   |   |                                      |

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл          | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1                  | 2            | 3                         | 4          | 5        | 6        | 7                             | 8        |
|                    |              |                           |            |          |          |                               |          |
|                    |              |                           |            |          |          |                               |          |
| Тендерийн нийт үнэ |              |                           |            |          |          |                               |          |

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч,<br>холбоо барих<br>хаяг/утас/факс | Гэрээний үнийн<br>дүн | Гэрээний эхлэх<br>хугацаа | Гэрээний<br>дуусах хугацаа |
|--------------|--|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1.           |  |                       |                           |                            |
| 2.           |  |                       |                           |                            |
| 3.           |  |                       |                           |                            |
| 4.           |  |                       |                           |                            |
| 5.           |  |                       |                           |                            |
| бусад.       |  |                       |                           |                            |

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. Барааг нийлүүлэхдээ Захиалагчийн томилогдсон ажилтанд шалгуулан хүлээлгэж өгнө.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) барааны гарал үүслийн гэрчилгээ.
  - 4) нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхэд захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын хугацаан дахь засвар үйлчилгээг хариуцна.
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Урьдчилгаа төлбөр олгохгүй. Барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. Барааг сар бүрийн 05-ны өдөр захиалагчийн захиалсан тоо хэмжээгээр нийлүүлэх ба төлбөрийг гүйцэтгэлээр хийнэ.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup> 9.1. Алданги оногдуулах хувь: **0,5%**
- Алдангийн нийт дүн: **Гэрээний үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй**

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

| ЗАХИАЛАГЧ       | НИЙЛҮҮЛЭГЧ      |
|-----------------|-----------------|
| _____           | _____           |
| (Тамга, тэмдэг) | (Тамга, тэмдэг) |
| _____           | _____           |
| (Гарын үсэг)    | (Гарын үсэг)    |
| _____           | _____           |
| (Албан тушаал)  | (Албан тушаал)  |

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*